

Бугат сумын орон нутгийн төсөвт байгууллагуудад
санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

НЭГ: ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Бугат сумын Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2015, 2016 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нийцүүлэн шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

ХОЁР: ШАЛГАЛТ ХИЙСЭН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, Аудитын албаны даргын баталсан 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/19 дүгээр удирдамжийн дагуу Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Сарангэрэл 2017 оны 10 дугаар сарын 09-өөс 10 дугаар сарын 17-ныг дуусталх өдрүүдэд хяналт шалгалт хийв.

ГУРАВ: ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД.

Санхүүгийн анхан шатны баримт, санхүүгийн тайлан, эд хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, тооллогын материалууд, нийгмийн даатгалын төлөлт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заасан асуудлуудыг шалгалтанд бүрэн хамруулав.

ДӨРӨВ: ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.

Булган аймгийн Бугат сумын ИТХ нь 2 ажилтантай ба үүнээс удирдах 1, гүйцэтгэх 1, мөн багийн иргэдийн нийтийн хурлын дарга 3 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна. ЗДТГ нь 28 ажиллагсадтай ба үүнээс удирдах 3, гүйцэтгэх 12, үйлчилгээний 2, гэрээт 7, багийн засаг дарга 3 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна

ИТХ-д 1-р гарын үсгийг ИТХ-ын дарга Д.Дэмбэрэлдорж, М.Сүхбаатар нар, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Ж.Жаргалсайхан, П.Мөнхтогтоо нар зурж төрийн санд бүртгэлийн 040254001 данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгийг мөнгийг захиран зарцуулсан байна.

ЗДТГ,Багт 1-р гарын үсгийг Тамгын газрын дарга Ц.Алтсайхан, 2-р гарын үсгийн нягтлан бодогч Ж.Жаргалсайхан, П.Мөнхтогтоо нар зурж төрийн санд бүртгэлийн 040255001, нэмэлт санхүүжилтийн 040255405 данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн “CTS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ: ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.

Аймгийн Аудитын газраас 2015, 2016 онуудад ИТХ зөрчилгүй дүгнэлттэй ЗДТГ, Баг түүвэрт хамрагдсан байна.

ЗУРГАА: ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДЛУУД.

Шалгалтын явцад 2015, 2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ албан томилолтын бодолт, тооцоололт, цалин хөлсний бодолт, тогтоолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг авто машины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, орлогын бүрдүүлэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, шилэн дансны тухай хэрэгжилтийг тооцон, байгууллагын дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

6.1 Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар.

ИТХ: Тус байгууллага нь 2015 онд орон нутгийн төсвөөс 38207.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 36635.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 34991.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 1644.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 5923.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тус байгууллага нь 2016 онд орон нутгийн төсвөөс 37239.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 37189.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 33645.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 3351.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1047.6 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 192.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ЗДТГ: Тус байгууллага нь 2015 онд орон нутгийн төсвөөс 217453.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 1200.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 5363.3 мянган төгрөг, БОЯ-аас 3000.0 мянган төгрөг, нийт 230105.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 178980.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 38534.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 12589.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тус байгууллага нь 2016 онд орон нутгийн төсвөөс 216430.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 14557.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 19256.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 2503.7 мянган төгрөг нийт 256452.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 168162.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 87396.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 894.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Баг: Тус байгууллага нь 2015 онд орон нутгийн төсвөөс 32906.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай

холбоотой зардалд 27402.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 1388.1 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 5847.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тус байгууллага нь 2016 онд орон нутгийн төсвөөс 34681.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 32828.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 1853.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6.2 Үндсэн хөрөнгө бараа материалын өөрчлөлт.

ИТХ: 2015 онд 11418.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан байсан бөгөөд шалгалтанд хамрагдсан тайлант онд хөрөнгө нэмэгдэж хасагдаагүй данс бүртгэлд тусгажээ.

2015 оны эхэнд 22.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1075.9 мянган төгрөгийн аж ахуйн материалтай байсан ба тайлант хугацаанд 45.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 122.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 857.0 мянган төгрөгийн түлш, шатахуун орлогод авч, 65.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 258.7 мянган төгрөгийн аж ахуйн материал, 857.0 мянган төгрөгийн түлш, шатахуун зарцуулан оны эцэст 2.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 939.2 мянган төгрөгийн аж ахуйн материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2016 онд 11418.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан байсан бөгөөд шалгалтанд хамрагдсан тайлант онд хөрөнгө нэмэгдэж хасагдаагүй данс бүртгэлд тусгажээ

2016 оны эхэнд 2.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 939.2 мянган төгрөгийн аж ахуйн материалтай байсан ба тайлант хугацаанд 99.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 37.5.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1081.2 мянган төгрөгийн түлш, шатахуун орлогод авч, 99.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1081.2 мянган төгрөгийн түлш, шатахуун зарцуулан оны эцэст 2.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 976.7 мянган төгрөгийн аж ахуйн материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна

ЗДТГ: 2015 оны эхэнд 1512114.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан 439700.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. Үүнээс БХС-ийн хөрөнгөөр 15665.7 мянган төгрөгийн, төсөл хөтөлбөрөөр 197619.2 мянган төгрөгийн, ОНХС-аар 226416.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан ба 11232.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж данс бүртгэлээс хасаж оны эцэст нийт 1940582.5 мянган төгрөгийн хөрөнгөтэйгээр данс бүртгэлд тусгажээ.

2015 оны эхэнд бараа материал 64749.6 мянган төгрөг байсан ба 19280.6 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн 1097.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 64.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 10381.2 мянган төгрөгийн түлш шатахуун, 1270.0 мянган төгрөгийн малын нас дэвшилт, 6468.0 мянган төгрөгийн аж ахуйн материал төсвийн хөрөнгөөр худалдан авсан ба 1802.0 мянган төгрөгийн аж ахуйн материал хандиваар, 1990.0 мянган төгрөгийн аж ахуйн материал БОАЖГ-аас шилжүүлэн, 1095.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг ОНХС-аас авч, 1077.4

мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 3379.7 мянган төгрөгийн аж ахуйн материал, 64.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 6729.2 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг тус тус зарцуулж, 443.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 180.0 мянган төгрөгийн мал зүй бусаар хорогдсон, 560.0 мянган төгрөгийн мал нас дэвшилтээр хасаж 283.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 27438.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2502.4 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 3652.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 37720.0 мянган төгрөгийн малыг тус тус данс бүртгэлд үлдэгдлээр тусгасан байна.

2016 оны эхэнд 1940582.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан 11787.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. Үүнээс төсвийн хөрөнгөөр 28.0 мянган төгрөг, БХС-аар 299.9 мянган төгрөг, ОНХС-аар 10000.0 мянган төгрөгийн худаг, хандиваар 740.0 мянган төгрөгийн сандал, ширээ, асар шилжүүлэн авсан ба оны эцэст нийт 1952370.4 мянган төгрөгийн хөрөнгөтэйгээр данс бүртгэлд тусгажээ.

2016 оны эхэнд бараа материал 71596.4 мянган төгрөг байсан ба 27243.6 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн 1025.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1806.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 17848.3 мянган төгрөгийн түлш шатахуун, 576.6 мянган төгрөгийн аж ахуйн материал төсвийн хөрөнгөөр худалдан авсан ба 249.0 мянган төгрөгийн аж ахуйн материал хандиваар, 109.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал 1451.8 мянган төгрөгийн аж ахуйн материал БХС-аас шилжүүлэн, 329.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, 309.0 мянган төгрөгийн сэлбэгийг бусад хэлбэрээр авч, 1115.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 990.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 850.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 17679.7 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг тус тус зарцуулж, 302.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 29054.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 3767.7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 5709.5 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 36180.0 мянган төгрөгийн малыг тус тус данс бүртгэлд үлдэгдлээр тусгасан байна.

Баг: 2015 оны эхэнд 45386.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан бөгөөд шалгалтанд хамрагдсан хугацаанд үндсэн хөрөнгө нэмэгдэж, хасагдаагүй оны эцэст 45386.9 мянган төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд тусгасан байна.

2015 оны эхэнд 85.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 730.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 700.0 мянган төгрөгийн малтай байсан ба тайлант хугацаанд 25.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 250.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 380.0 мянган төгрөгийн түлш, шатахуун орлогод авч, 89.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 250.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 380.0 мянган төгрөгийн түлш, шатахуун зарцуулан оны эцэст 21.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 730.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 700.0 мянган төгрөгийн малын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2016 оны эхэнд 45386.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан бөгөөд шалгалтанд хамрагдсан хугацаанд үндсэн хөрөнгө нэмэгдэж, хасагдаагүй оны эцэст 45386.9 мянган төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд тусгасан байна.

2016 оны эхэнд 21.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 730.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 700.0 мянган төгрөгийн малтай байсан ба тайлант хугацаанд 198.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 175.7 мянган төгрөгийн аж ахуйн материал, 824.6 мянган төгрөгийн түлш, шатахуун орлогод авч, 154.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 137.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 722.7 мянган төгрөгийн түлш, шатахуун зарцуулан оны эцэст 65.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 769.3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 101.9 мянган төгрөгийн түлш шатахуун, 700.0 мянган төгрөгийн малын үлдэгдэлтэй тайлагнасан байна

6.3: Авлага, өглөг:

ИТХ: 2015 оны эхэнд өглөггүй байсан, 37502.2 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж, 36335.0 мянган төгрөгийн өглөг хасагдаж 1167.3 мянган төгрөгийн өглөгтэй, авлагагүй тайлан баланс гарсан байна. /Цалингийн өглөг 79338 төгрөг, НДШ-ийн өглөг 402.5 мянган төгрөг, татварын өглөг 475.4 мянган төгрөг, шатахууны өглөг 210.0 мянган төгрөг/

2016 оны эхэнд өглөг 1167.3 мянган төгрөг байснаас 35572.2 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж, 36739.5 мянган төгрөгийн өглөг хасагдаж өглөггүй, 138.9 мянган төгрөгийн авлагатай тайлан баланс гарсан байна

ЗДТГ: 2015 оны эхэнд өглөггүй байснаас 222817.7 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж 212850.3 мянган төгрөгийн өглөг хасагдаж 9967.4 мянган төгрөгийн өглөгтэй /цалингийн өглөг 4697.5 мянган төгрөг, НДШ-ийн авлага 1851.7 мянган төгрөг, татварын авлага 1338.2 мянган төгрөг, бичиг хэргийн өглөг 76.7 мянган төгрөг, түлш халаалтын өглөг 246.0 мянган төгрөг, шатахууны өглөг 975.4 мянган төгрөг, томилолтын өглөг 492.0 мянган төгрөг/, авлагын эхний үлдэгдэл 9.4 мянган төгрөг байснаас 6489.2 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, 3097.9 мянган төгрөгийн авлага хасагдаж 3075.6 мянган авлага нь төвлөрүүлсэн, 325.0 БХС-аас авах авлага тус тус данс бүртгэлд тусгасан байна.

2016 оны эхэнд 9967.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байсан ба 216172.6 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж, 225773.3 мянган төгрөгийн өглөг хасагдаж 366.7 мянган төгрөгийн өглөгтэй, авлагын эхний үлдэгдэл 3400.6 мянган төгрөг байснаас 3703.0 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, 6778.7 мянган төгрөгийн авлага хасагдаж 325.0 мянган төгрөгийн БХС-аас авах авлагыг тус тус данс бүртгэлд тусгасан байна

Баг: 2015 оны эхэнд өглөггүй байснаас 30765.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 26674.2 мянган төгрөгөөр хасагдаж 4091.3 мянган төгрөгийн өглөгтэй /цалингийн өглөг 496.0 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 2490.0 мянган төгрөг, татварын өглөг 1105.2 мянган төгрөг/, авлагагүй тайлан баланс гаргасан байна.

2016 оны эхэнд 4091.3 мянган төгрөгийн өглөгтэй байснаас 30533.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 34625.2 мянган төгрөгөөр хасагдаж, өглөггүй, авлагагүй тайлан баланс гаргасан байна.

6.4: Засаг даргын нөөц сангийн зарцуулалт:

Он	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
2015	10000.0	7500.0	75.0
2016	10000.0	10000.0	100.0

6.5 Нэмэлт санхүүжилтийн дансаар:

ЗДТГ: 2015 онд гамшгаас хамгаалах сангаас томилолтын зардалд 4320.0 мянган төгрөг, тооллогод 478.6 мянган төгрөг зарцуулж, 75.6 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

2016 онд БОЯ-аас 3000.0 мянган тбгрбг, аймгаас хог цэвэрлэх зориулалтаар 500.0 мянган төгрөг, Амар сайдын ой тэмдэглэхэд хандиваар 9936.1 мянган төгрөг, тооллогод 545.9 мянган төгрөг, ОНХС-аас 500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 75.6 мянган төгрөг төвлөрүүлэн зарцуулсан байна.

6.6 Шилэн дансны хуулийн хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагч: Төсөв гүйцэтгэл цэсний 57 мэдээлэл мэдээлэхээс 18 мэдээлэл хоцроосон, тендэр худалдан авалт цэсний 20 мэдээлэл мэдээлэхээс 9 мэдээлэл хоцроосон, бусад цэсний 28 мэдээлэл мэдээлэхээс 16 мэдээлэл хоцроосон,

Иргэдийн төлөөлөгчдийн хурал: Төсөв гүйцэтгэл цэсний 35 мэдээлэл мэдээлэхээс 3 мэдээлэл хоцроосон, тендэр худалдан авалт цэсний 28 мэдээлэл мэдээлэхээс 3 мэдээлэл хоцроосон, бусад цэсний 46 мэдээлэл мэдээлэхээс 3 мэдээлэл хоцроосон,

Засаг даргын Тамгын газар: Төсөв гүйцэтгэл цэсний 35 мэдээлэл мэдээлэхээс 2 мэдээлэл хоцроосон, тендэр худалдан авалт цэсний 28 мэдээлэл мэдээлэхээс 2 мэдээлэл хоцроосон, бусад цэсний 46 мэдээлэл мэдээлэхээс 3 мэдээлэл хоцроосон байна.

ДОЛОО: ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ.

1. Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалыг /2016 оны/ үдэж архивлаагүй нь Архивын тухай хуулийн 6.4.3. /төрийн өмчийн болон төрийн өмч оролцсон хуулийн этгээд, улсын төсөвт байгууллагын архивын баримт/, 22.1.3. /баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн хэрэг бүрдүүлэх, албан хэрэгт хөтлөгдөх хугацаа дуусмагц зохих журмын дагуу цэгцэлж, бүрэн бүрдэлтэйгээр байгууллагын архивт шилжүүлэх;/ заалтуудыг.

2. Хандиваар 2016 онд ирсэн 20000 үнэтэй сандал 1 ширхэг, 70000 төгрөгийн үнэтэй ширээ, 650000 төгрөгийн асар 1 ширхэг, БХС-ын хөрөнгөөр бэлтгэсэн 299.9 мянган төгрөгийн үнэтэй 3 үйлдэлт принтер 1 ширхэгийг тус тус тусгаагүй, нэг бүр нь 20000 төгрөгийн үнэтэй 3 ширхэг номыг өглөгийн бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4./Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ;14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;14.4.3.бүх өр төлбөр;/ заалтуудыг

3. Ажилтнуудын цалинг амралтын олговортой давхардуулж /Д.Лхагвасүрэн 8-р сард 6 хоног ажилласан, 18 хоногийн амралтын олговор авсан 1 хоног давхардсан (19966төгрөг), Б.Үүрийнцолмон 7-р сард 11 хоног, 8-р сард 10 хоног ажилласан, 2 хоног хуулиар зөвшөөрөгдсөн, 2 хоног тасалсан, 18 хоногийн амралтын олговор авсан 1 хоног давхардсан (22114 төгрөг), Ө.Энхтайван 7-р сард 11 хоног ажилласан, 8-р сард 7 хоног ажилласан, 6 хоног тасалсан, 18 хоногийн амралтын олговор авсан 2 хоног давхардсан (61618 төгрөг), Ц.Алтсайхан 8-р сард 10 хоног ажилласан, 9-р сард 10 хоног ажилласан, 26 хоногийн амралтын олговор олгож 1 хоног давхардсан (61618 төгрөг), Ж.Ганбат 8-р сард 10 хоног ажилласан, 9-р сард 10 хоног ажилласан, 26 хоногийн амралтын олговор олгож 1 хоног давхардсан (30690 төгрөг), Д.Дэмбэрэлдорж 7-р сард бүтэн ажилласан, амралтын олговрыг 7, 8-р сард 2 удаа 29 хоногоор тооцож амралтын олговор олгосон (1677389 төгрөг), С.Эрдэнэбаяр 7-р сард 11 хоног ажилласан, 8-р сард 18 хоног ажилласан амралтын олговор 18 хоногоор олгож, 3 хоног давхардсан (108642 төгрөг) нийт 1974301 төгрөг илүү олгож үргүй зардал гаргасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55.1. /Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд ээлжийн амралтын олговор олгоно./, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 13-д /Ажил олгогч нь ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй/ заалтуудыг

4. Ажиллагсдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгохдоо төрийн албанд ажилласан хугацааг тооцолгүй Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 2-р хавсралтыг зөрчиж ажилтны бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэж захирамж гаргаснаас Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Ө.Энхтайванд 2015 оны 1-р сараас 2016 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд 2015 онд 719013 төгрөг, 2016 онд 537162 төгрөг нийт 1256175 төгрөгийг илүү олгосон, мөн санхүүгийн албаны дарга Т.Гантулгад 2015 онд Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд 1562535 төгрөг олгосон ба 2015 оны 06 дугаар сарын 08-ны Б/22 дугаар захирамжаар ТҮ-9-5 шатлалаар шийдвэр гарсан байна. ТҮ шатлалаар цалинжиж байгаа ажилтанд ТАХ-ны нэмэгдэлд 2015 онд 839958 төгрөг, 2016 онд 226300 төгрөг бүгд 1066258 төгрөг илүү олгосон байна.

5. Албан томилолтын зардалд /Б.Ариунжаргал (2015), Л.Жалбуусүрэн, П.Мөнхтогтоо, Т.Гантулга, С.Нямсүрэн нар Улаанбаатар хотод ажиллахад тус бүр 1 хоногийн 35500 төгрөг илүү олгосон, Г.Пунсалдулам Хангал суманд ажиллахад аймагт ажилласнаар тооцож 22000 төгрөг илүү, Ц.Алтсайхан Булганд 1 хоног, Хөвсгөлд 1 хоног 58000 төгрөг илүү/ бүгд 160500 төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийн 8-д /Зам хоногийн зардлыг тухайн үеийн бараа, үйлчилгээний үнэ,

тарифыг үндэслэн Сангийн сайдын шийдвэрээр баталсан уг зардлын хэмжээг баримтлан олгоно./ 9.-д /Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн бүх хоногоор тооцож гаргана. Тэгэхдээ явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно./, Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалын 1-д / төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын хэмжээг суманд 18000 төгрөг...../ заалтуудыг

6. Тамгын газрын ажилтнуудад хүүхдийн баяраар бэлгэнд 145.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5./Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах 16.5.5/ заалтыг.

7. Тамгын газар 2015 оны 06 дугаар сараас 6 иргэнд үйлчилгээний байр түрээслүүлэн 860.0 мянган төгрөгийг төвлөрүүлж 330.0 мянган төгрөг дутуу, 2016 онд 1610.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн 430.0 мянган төгрөг дутуу нийтдээ 760.0 мянган төгрөг төвлөрүүлээгүй нь

8. Ажилтнуудад 2015 онд И.Пүрэвмядагд 1350.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, 1050.0 мянган төгрөгийг суутгаж 300.0 мянган төгрөг суутгаагүй, Д.Лхагвасүрэнд 1230.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож 980.0 мянган төгрөгийг суутгаж 250.0 мянган төгрөг суутгаагүй нийтдээ 550.0 мянган төгрөг суутгаагүй ба данс бүртгэлд авлагаар тусгаагүй

9. 2015 оны үр дүнгийн гэрээний урамшуулалд Т.Гантулгад 568984 төгрөг, Ө.Энхтайванд 383431 төгрөг, Д.Отгонбаярт 442887 төгрөг, С.Эрдэнэбаярт 442887 төгрөг бүгд 1838189 төгрөг олгосон нь байгууллагын дотоод журмын 10.7 -г зөрчсөн байна.

10. Цалингаас бусад зардлуудыг бэлнээр гаргаж байна. Тухайлбал сумын дүнгээр 2015 онд 32818239 төгрөг, 2016 онд 42684561.50 төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ

Байгууллагын дотоод хяналт хэрэгжүүлээгүйгээс зөрчил дутагдал илрэх шалтгаан болсон байна.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ:

Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 8810323 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

АРВАН НЭГ: ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ШИЙДВЭРЛЭВЭЛ ЗОХИХ АСУУДАЛ.

1. Анхан шатны баримтыг хуулийн дагуу бүрдүүлэхгүйгээр гүйлгээ хийдэг, зардал гаргадаг явдлыг таслан зогсоож Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр

илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах, жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэлд зардлын бүлэг болон эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан тухай тайлангийн тодруулгад дэлгэрэнгүй тусгаж байх.

2. Албан томилолтоор ажиллуулах тохиолдолд тухайн арга хэмжээний хөтөлбөр, дээд байгууллага, албан тушаалтны шийдвэр, албан томилолтын хугацаанд хийх ажлын удирдамжийг үндэслэн томилолтын үнэмлэхийг олгох, ажлын гүйцэтгэлийг албан томилолт олгосон эрх бүхий этгээд дүгнэж зардлыг хэдэн хувиар олгохыг баталгаажуулж, Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ыг мөрдөж, томилолтын зардлыг зөв бодож, олгож байх.

3. Сэлбэг, шатахууны зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, автомашины хувийн хэрэг хөтлөх, жолооч бүрээр шатахууны тоцоог бодож хэвших, автомашины шатахууны 100 км-т зарцуулах нормыг тооцохдоо Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм”, “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар”-ыг мөрдөж ажиллах.

4. Анхан шатны баримтын бүрдлийг тухай бүр хангаж, бараа материал, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг сар бүр, үндсэн хөрөнгийн тайланг хагас бүтэн жилээр гаргаж, Монгол Улсын Сангийн сайдын 2000 оны 69 тоот тушаалаар баталсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийг мөрдөж ажиллах.

5. Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх.

6. Төлбөрийн төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн Төрийн сангийн хүү торгуулийн орлогын 100040000952 тоот дансанд төвлөрүүлэхийг ИТХ-ын дарга Ундрах, Засаг дарга Х.Ууганбаяр, Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Пүрэвсүрэн, Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дагийсүрэн, нягтлан бодогч П.Мөнхтогтоо нарт хариуцуулав.

7. Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулан улсын ахлах байцаагчийн өгсөн албан шаардлагын биелэлтийг бүрэн хангуулж, 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, Аудитын албанд албан бичгээр болон sankhuu_audit_bu@yahoo.com хаягаар хариу ирүүлэх

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ Д.САРАНГЭРЭЛ